



МОНГОЛ КЕРАМИК

Сонгинохайрхан дүүрэг, 7-р хороо

Улаанбаатар хот, Монгол улс

Утас: +976 99175309, 80111144

E-mail: eb.ulzii@gmail.com

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ПРОТОКОЛ

2024.04.29 № 01

“Монгол керамик” Хувьцаат Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2024 оны 04 дүгээр сарын 27-ний өдрийн 09⁰⁰ цагт СХДүүрэг 14-р хороо, “Цамбагарав” үйлчилгээний төвийн баруун талд “Номын сан”-гийн байранд хуралдав.

Хуралд ТУЗ-ийн дарга Б.Эрдэнэбилэг, Гүйцэтгэх захирал Э.Өлзийбаяр, гишүүн Т.Батмөнх, гишүүн Л.Уранцэцэг, гишүүн Д.Адьяасүрэн, гишүүн Г.Базарсад, гишүүн С.Хишигжаргал, гишүүн М.Буянжаргал, хувьцаа эзэмшигч С.Мягмарсүрэн, хувьцаа эзэмшигч С.Пүрэвжав нар оролцов.

Хувьцаа эзэмшигч Б.Эрдэнэбилэг	271,809 ш	85,23%	
Хувьцаа эзэмшигч Д.Адьяасүрэн	13,287 ш	4,2%	
Хувьцаа эзэмшигч Т.Батмөнх	1,000 ш	0,31%	
Хувьцаа эзэмшигч С.Мягмарсүрэн	2,800 ш	0,87%	
Хувьцаа эзэмшигч С.Пүрэвжав	560 ш	0,17%	
Нийт хувь		90,78%-ийн	хувьцаа

эзэмшигчтэй, хурал эхлэв.

“Монгол керамик” ХКомпанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг нээж ТУЗ-ийн дарга Б.Эрдэнэбилэг үг хэлэв.

ТУЗ-ийн дарга Б.Эрдэнэбилэг:

Гишүүдэд энэ өдрийн мэнд хүргэе. 2023 оны “Монгол керамик” ХКомпанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал эхэлснийг мэдэгдье. Хурлаар доорх 5 асуудлыг хэлэлцэж шийдвэрлэе. Энэ ээлжит хуралд хоёр хүнийг урилгаар оролцуулж байна. “Том нар” ХХКомпанийг төлөөлж санхүү хөрөнгө оруулалт эрхэлсэн захирал Сумъяадорж, Японы хөрөнгө оруулагч “Asian Gateway corporation” Компанийг төлөөлж Монгол дахь албан ёсны төлөөлөгч Буянхишиг нар юмаа. Энэ хоёр компаний талаар дараа нь тодорхой танилцуулна. Компаний гишүүн С.Гончиг гуайн биеийн байдал тааруу хагалгаанд орсон тул биеэр ирж чадахгүй гэдгээ хэлсэн. Хурлаас гарсан шийдвэрийг танилцуулаад гарын үсгийг очиж зуруулахаар тохиролцсон шүү. Хэлэлцэх асуудлуудаа дарааллын дагуу танилцуулъя. Тэгээд гишүүд саналаа хэлнэ үү.

Хурлын хэлэлцэх асуудал:

1. Компаний 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах.

2. Компаний 2023 оны үйл ажиллагааны төсөв төлөвлөгөөг хэлэлцэж батлах.
 3. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг томилох.
 4. Компаний хөрөнгө оруулалтын талаар хэлэлцэж батлах.
 5. Компанийн гишүүд, нарын бичгийн даргын цалин, ТУЗ-ийн зардлын төсвийг батлах
-
1. **Компаний 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах нь:** Компани нь 2019 оноос үйл ажиллагаа явуулаагүй, үйлдвэр бүрэн зогссон байсан. 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэж байгаар санхүү бол ойлгомжтой алдагдалтай өр ширтэй хүнд байгаа, өмнө нь банкнаас санхүүжилт болгон авсан 7,000,000,000 долоон тэр бум төгрөгийн үндсэн зээл хүүгийн хамт төлж дуусгаагүй өдий хүрлээ. 2023 онд тоосгоны үйлдвэрээ ажиллуулахаар 1,000,000,000 нэг тэр бум төгрөгийн санхүүжилт оруулсан боловч доривтой ажиллаж чадаагүй, тоосго бүтээгдэхүүн миний санаанд хүрхээр үйлдвэрлэж чадсангүй ээ энэ талаар гүйцэтгэх захирал болон санхүүгийн албаныхан ярьна биз. Эдгээр хүндрэлээс болж үйлдвэрээ бүрэн зогсоож хаахад хүрээд байна.
 2. **Компаний 2024 оны үйл ажиллагааны төсөв төлөвлөгөөг хэлэлцэж батлах нь:** Барилгын компаниуд болон орон сууц барьж байгаа газрууд дандаа бетон цутгалтаар хийдэг болсон тул хана хоорондын дүүргэлтэд тоосго ашиглахаа больж тоосгоны хэрэглээ багасч муудаж байна. Иймээс цаашид тоосгоны үйлдвэрлэлийн чиглэлээ бүрэн зогсоож, өөр үйл ажиллагаа явуулах өөрчлөлт оруулах саналтай байна.
 3. **ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг томилох талаар:** Компаний үйл ажиллагаа зогсонго байдалтай үйл ажиллагаа явуулахгүй байгаа тул ердийн болон хараат бус гишүүдийг томилох талаар энэ удаад ярьмааргүй байна. Уг нь хэн хэнийг томилох яах талаар бичгээр санал авах анкетаа өг гээд байхад одоо болтол ямарч хүний материал ирээгүй тул хойшлуулж дараагийн хурлаар хийдвэрлэх саналтай байна.
 4. **Компаний хөрөнгө оруулалтын талаар хэлэлцэх:** Компанид болон тоосгоны үйлдвэрт бол ахиж хөрөнгө оруулалт хийхгүй урдны оруулсан хөрөнгө оруулалтын төлбөрөө авч чадахгүй одоо бүр шүүхээр шийдүүлэхээр болоод байна. Ийм учраас барилга байгууламж объект, хөрөнгө үл хөдлөх хөрөнгө, газраа ашиглан үйл ажиллагааны чиглэлээ өөрчилж цахилгаан эрчим хүчний цэнэг хураагуурын чиглэлээр хамтран ажиллаж үйл ажиллагаа явуулах саналтай байна. Ийм учраас “Том нар” ХХК болон Японы хөрөнгө оруулагч нарын төлөөллийн хүмүүсийг урьж хуралд оролцуулж байна. Яаж хамтрах вэ? гэвэл “Монгол керамик” ХКомпанийн эзэмшлийн шаврын ордны газар болон үйлдвэрийн хашаан доторх газраас 0,7 га газрыг ашиглан эзэмшүүлэх чиглэлээр “Том нар” ХХКомпанид 20 жилийн хугацаатайгаар түрээслүүлэх саналтай байна гишүүд юу гэж бодож байна саналаа хэлнэ үү.
 5. **Компанийн гишүүд, нарийн бичгийн даргын цалин, ТУЗ-ийн зардлын төсвийг батлах:** Компани ийм хүнд байдалтай байхад гишүүдийн цалин, ТУЗ-ийн зардлын төсөв батлах зэрэг нь цагаа олоогүй асуудал байна. Энэ талаар дараа ярилцаж шийдвэрлэе. Гишүүд санал бодлоо хэлнэ үү.

Гишүүн: Э.Өлзийбаяр.

Гишүүддээ энэ өдрийн мэнд хүргье. Компани маань үйл ажиллагаа явуулаагүй олон жил зогссон учир санхүүгийн хувьд бол хүнд байгаа. Банкны зээл, дээр нь газрын төлбөр,

татварын өр, НД-ийн өр гэх мэт. 2023 онд 1,000,000,000 нэг тэр бум төгрөгийн санхүүжилт аваад тоосгоны үйлдвэрээ ажиллуулахаар БНХАУ-аас өндөр зэрэглэлийн ИТА-д урьж ажиллуулсан. Үйлдвэр олон жил ажиллаагүй учир тоног төхөөрөмж, техникүүдэд нилээд засвар үйлчилгээ хийж байж ажилд оруулсан. Улаанбаатар хотод түүхий нүүрс оруулахаа больсонтой холбогдуулж УҮХолбоотойгоо хамтран ажиллаж Таван толгой түлш ХХКомпаниас сайжруулсан түлш мидлинг авахаар гэрээ хийж Өмнөговийн Цогтцэцийгээс тээвэрлэлт хийж авсан. Хуучин бол Налайхаас түүхий нүүрс авдаг байсан 1тн 60,000-70,000 төгрөгөөр авдаг байсан одоо мидлинг 1тн 285,000-305,000 төгрөгөөр авсан. Өртөг өндөртэй болоод бүтээгдэхүүнээ зах зээлд боломжийн үнээр зарах хүсэлтэй байсан боловч барилгууд бетон цутгалтаар хийдэг болсонтойгоор тоосгоны хэрэглээ багассан байна. 2-3 барилгын компанид тоосго нийлүүлсэн боловч бартерийн гэрээ хийсэн тул үлдэгдэл төлбөрүүд орж ирээгүй байгаа. Ийм хүдэтгэх шалтгаануудаас болж үйлдвэр ашиггүй ажилласан. ХХБанкнаас авсан зээл зээлийн хүүний төлбөр төлөлт хийгдээгүй маргаантай байгаа учир ХХБанк шүүхээр шийдвэрлүүлэхээр шүүхэд манай компанийг өгсөн шүүх хурал хойшлогдоод явж байгаа.

Гишүүн: Т.Батмөнх

Гишүүдэдээ энэ өдрийн мэнд хүргэе. Ийм хүнд үед ажиллахад бэрх байна. 2019 оноос үйл ажиллагаа яваагүй болохоор санхүүгийн хувьд хүнд байна хэдэн хүмүүсийн цалингаа алдан онон тавьж, татвар, НД шимтгэлд нилээн өр хуримтлагдаж 2023 онд үйлдвэр гайгүй ажиллах болвуу гэтэл санаанд хүрч ажилласангүй, сайжруулсан түлш мидлинг нь өртөг өндөртэй ирж байсан, дээр нь ажиллах хүчин олдохоо больсон байна, борлуулалт муутай ахиад л өр нэмэгдээд. Санхүүгийн тайлан алдагдалтай гарч байгааг та бүхэн мэдэж байгаа. ТУЗ-ийн даргийн хэлснээр үйл ажиллагааны чиглэлээ өөрчилвөл зүгээр байна. Тэгж байж л энэ өр ширээ багасгаж, төлж дуусгахгүй бол өдөр өдрөөр л нэмэгдээд байна шүү. 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөндөө өөрчлөлт оруулъя. Тэр цахилгаан цэнэг хураагуур, буюу миний ойлгосноор тог хураагуур зай хийдэг, тусгай зөвшөөрөлтэй компани юм бол компанийхаа ашиглахгүй байгаа объект, газар талбайгаа боломжийн үнээр түрээслэх нь зөв шийдвэр хамтран ажиллахад татгалзах зүйл алгаа. Дэмжиж байна.

Гишүүн: Л.Уранцэцэг.

Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе: 2023 онд тоосгоны үйлдвэрээ нээж ажиллуулсан Компаний санхүү хүнд байгааг бүгд ойлгож байгаа, БНХАУ-аас өндөр зэрэглэлийн инженер техникийн ажилчдаа Монгол улсдаа оруулж ирнэ гэдэг том ажил шүү. Өлзийбаяр захирал урдаас хятад ажилчдаа оруулж ирэхдээ үйлдвэрээ эхлэх санхүүжилт тоосго зөөх цахилгаан машинууд, тоног төхөөрөмжийн сэлбэгүүд авчирсан нь үйлвэрээ ажилд оруулахад том хувь нэмэр болсон. Өнгөрсөн жил сайн дулаарч өгөхгүй хүйтэн байсан, сайжруулсан түлш мидлинг нь олдохгүй үнэтэй хуучин нүүрсийг бодвол илчлэг ихтэй тул галын тохиргоо туршилт хийх гээд ажил явуулахад хүндрэлтэй байлаа. Энэ тал дээр анхаарч үйлдвэрээ хурдан ажилд оруулж жигдрүүлэх тал дээр бүгд хичээж ажилласан. Орчин үед тоосгоны хэрэглээ багасаж байгаа юм бол үйл ажиллагаагаа өөрчилж өөр чиглэлээр үйлдвэрийн агуулах, талбайгаа түрээслэж мөнгө олох тал дээр ажиллавал зүгээр байна. Мөн банкнаас авсан зээлийн төлөлтийг сунгуулах, хүүг бууруулах талаар банкинд холбогдох бичиг баримтыг бүрдүүлж өгч байсан төлөлт хийгдэхгүй болхоор банк шүүхэд хандаж байгаа юм байна хэцүүхэн л юм болж байнадаа. Төлж л барагдуулахгүй бол болохгүй тийм учраас тэр эрчим хүчний нарны цэнэг хураагуурын компанитай нь хамтарч ажиллавал зүгээр юм байна газраа удаан хугацаагаар түрээслэх нь зөв гэж бодож байна.

Гишүүн: Г.Базарсад

Өдрийн мэнд хүргэе. Санал нэгтэй байна, Банктайгаа ярилцаад ойлголцохгүй болхоор шүүхэд хандсан байгаа. 2023 онд тоосгоны үйлдвэр ашигтай ажиллах боломж байсан Мидлинг гэж сайжруулсан түлш нь илчлэг ихтэй өртөг өндөртэй түлш юмаа. Үйлдвэрийн Монгол-Хятад ИТАжилтангууд тооцоолол хийсэн боловч галын тохиргоогоо тохируулж чадаагүйн улмаас тоосгоо шатааж хайлуулан хайлш тоосго буюу ахиж ашиглаж болохгүй тоосго ихээр гаргасан. Энэ дээр хэн гэдэг албан тушаалтанд хариуцлага тооцох биш хариуцлагаа компани үүрээд ашиггүй ажилласан. Цаашид тоосгоны хэрэглээ буурч байгаа учир үйл ажиллагааны чиглэлээ өөрчлөх нь зүйтэй. Ердийн гишүүд болон хараат бус гишүүдийн асуудлыг үйл ажиллагаа жигдэрсний дараа шийдвэрлэх саналтай байна. Үйлдвэрийг зогсоож компанийн эзэмшлийн газрыг түрээслэх нь зөв гэж бодож байна.

Гишүүн: С.Хишигжаргал

Та бүхний ярьж байгаатай санал нэг байна. Ер нь тоосгоны үйлдвэрлэл явуулахад хүндрэлтэй болсон байна. Гол түүхий эд болох нүүрс мидлинг сайжруулсан түлш үнэтэй болсон, үйлдвэрт ажиллах ажилчид олдхоо больжээ. Залуу хүмүүс ажил хийхгүй байна. Ашиг олохоосоо илүү зардал гаргаж байгаа учир үйлдвэрээ зогсоосон нь дээр болжээ. 2024 ондоо үйл ажиллагааны чиглэлээ өөрчилж ажиллах тал дээр анхаармаар байна. Үйлдвэрийн болон шаврын ордны газраа түрээслэх нь зөв гэж бодож байна. Гишүүд болон нарийн бичгийн даргын цалин, Гишүүдийн зардлын төсвийг үйл ажиллагаа жигдэртэл түр хойшлуулж дараа хэлэлцэж батлах саналтай байна

Гишүүн: Д.Адьяасүрэн

Гишүүдэдээ өдрийн мэнд хүргий. 2023 онд тоосгоны үйлдвэрээ ажилд оруулаад сайн ажиллана гэж бодож байсан. Ер нь үйлдвэрлэл явуулахад хүндрэлтэй болжээ. Гишүүдийн ярьсныг давтаж яриад яахав. Үйлдвэрээ зогсоогоод үйл ажиллагааны чиглэлээ өөрчилж ажиллах нь зөв гэж бодож байна. Дэмжиж байна. Тийм учраас Батмөнх гишүүний ярьсантай санал нэг байна.

Гишүүн: М.Буянхишиг

Гишүүдийн саналыг сонслоо санал нэгтэй байна. Дэмжиж байна. Өөр хэлэх зүйл алгаа.

ТУЗ-ийн дарга: Э.Эрдэнэбилэг

За гишүүдийн саналыг сонслоо шийдвэрээ гаргая.

1. Компани 2023 онд үйл ажиллагаа тоосгоо үйлдвэрлэж явуулсан боловч сайн ажиллаж чадаагүй алдагдалтай байгаа, тоосго авсан барилгын компаниудаасаа үлдэгдэл төлбөрөө авч банкны зээл хүүндээ төлөх, татвар, газрын төлбөртөө боломжоороо төлж байхыг санхүүгийн алба, ня-бо Т.Батмөнх, гүйцэтгэх үахирал Э.Өлзийбаяр нарт даалгасугай.
2. 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөө үйлдвэрийн бүтэц зохин байгуулалтандаа өөрчлөлт оруулж үйлдвэрийг бүрэн зогсоож, өөр чиглэлээр ажиллуулсугай. Эрчим хүчний чиглэлээр (Нарны зай, цэнэг хураагуур) үйл ажиллагаа явуулдаг “Том нар”

ХХКомпанид үйлдвэрийн болон шаврын ордны газрыг ашиглан эзэмшүүлэх чиглэлээр 20 жилийн хугацаатайгаар түрээслүүлсүгэй.

Холбогдох бичиг баримт үйлдэх гэрээ хэлцэл хийх ажлыг гүйцэтгэх захирал Э.Өлзийбаярт даалгасугай.

3. ТУЗ-ийн ердийн гишүүдийг хэвээр баталсугай. Хараат бус гишүүдийн материал бичгээр ирээгүй учир хойшлуулж дараагийн хурлаар баталсугай.
4. Компаний хөрөнгө оруулалтын талаар “Том нар” ХХКомпани болон Японы хөрөнгө оруулалт хариуцсан Монгол талын захирал Буянхишигтэй ярилцаж шаврын ордны газар дээр сэргээгдэх эрчим хүчний чиглэлээр үйл ажиллагаа явуулах асуудал яригдаж байгаа тул ТУЗ болон гүйцэтгэх захирал нарт хариуцуулсугай.
5. Компанийн гишүүд болон нарийн бичгийн даргын цалин ТУЗ-ийн зардлын төсөвийн асуудлыг энэ удаад хойшлуулсугай.

ТУЗ-ийн дарга:

Б.Эрдэнэбилэг

Ердийн гишүүд:

Э.Өлзийбаяр

Т.Батмөнх

Д.Адъяасүрэн

С.Гончиг

Л.Уранцэцэг

С.Хишигжаргал

М.Буянжаргал

Г.Базарсад



[Handwritten signature]

[Handwritten signature]

[Handwritten signature]

[Handwritten signature]

[Handwritten signature]

[Handwritten signature]

[Handwritten signature]